



*Дундговь аймаг дахь
Төрийн аудитын
газрын 2017 оны эхний
хагас жилийн үйл
ажиллагааны тайлан*

Мандалговь
2017 он

Гарчиг

ӨМНӨХ ҮГ	3
Товчилсон үгийн тайлбар	4
Нэг. Удирдлага зохион байгуулалт	5
Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар	5
Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар	6
Дөрөв. Нийцлийн аудитын талаар	7
Тав. Өөрийн төлөвлөгөөт аудитын талаар	8
Зургаа. Дотоод ажлын талаар	9
Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар	10
Найм. Дүгнэлт, санал	11

ӨМНӨХ ҮГ

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг толилуулж байна.

Байгууллагын эрхэм зорилго, дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэхийн тулд аудитын тайланг чанаржуулах, улс, орон нутагт тулгамдаж буй олон нийтийн анхааралд байгаа, үнэн зөв хариу хүссэн асуудал буюу аудит хийх сэдвийн талаар санал солилцох зорилгоор төрийн аудитын байгууллагын ахмад ажилтнууд, судалгааны байгууллагын төлөөлөл оролцсон “Ахмадаа сонсьё” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан, ҮАГ-ын шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу байгууллагын нэр өөрчлөгдөж, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчоор /орон нутаг хариуцсан/ ахлуулсан ажлын хэсгийн үзлэг шалгалт хийгдэн, арга зүйн зөвлөмж өгсөн, мэргэжлийн тасралтгүй сургалтын хүрээнд УСНББОУС, мэдээлэл технологи, хүний хөгжил, хууль эрх зүйн мэдлэг олох сургалтыг мэргэжлийн байгууллагын сургагч багш нараар заалгаж зохих мэдлэг олж авсан зэрэг нь энэ тайлант хугацааны онцлог байв.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авсан /аймгийн хэмжээнд нийт төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан/, завсрын аудитыг 5 сум, аймгийн төвийн байгууллагуудыг хамруулан гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаас өмнө залруулах талаар зөвлөмж, акт, албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцсоноор санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд эерэг нөлөөлж, аудитаар өгсөн зөвлөмж үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.

Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тодорхой ажлууд хийж, СТАУС программд санхүүгийн тайлангийн аудитын ажлын баримт, тайланг оруулж, мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд дотоод сургалтыг зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.

Манай хамт олон Монгол Улсын Ерөнхий аудиторов дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэхийн төлөө хүний нөөцийн мэдлэг, ур чадвар, хариуцлагыг сайжруулах замаар аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхээр хичээн ажиллаж байна.

Хүндэтгэсэн

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ

Товчилсон үгийн тайлбар

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017-06-29

Мандалговь

Нэг. Удирдлага зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхий аудитор 2017 оныг “Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүй, бодлогын шинэтгэл, ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” жил болгох, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Боловсон хүчний мэдлэг, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх замаар аудитын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх”, мэдээллийн технологийн хөгжил дэвшилээс суралцаж, ололт амжилтыг бататган, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх” зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

Дээрх зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аудитын менежер, аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгуулав.

Аудитын менежер, аудитор, шинжээч нар тэргүүлэх аудитортой үр дүнгийн гэрээ байгуулан, үйлчилгээний ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг жилээр сунган ажиллаж байна.

Аудитын газар Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу санхүүгийн аудитын багт 4, гүйцэтгэлийн аудитын багт 2, нийцлийн аудитын багт 2 хүний бүрэлдэхүүнтэй, 3 багийн зохион байгуулалтаар нийт 11 орон тоогоор ажиллаж, аудитор Х.Гарам өөрийн хүсэлтээр 5 дугаар сарын 25-ны өдөр ажлаас чөлөөлөгдөв. Ажиллагсдын 9 буюу 90 хувь нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, 4 буюу 40 хувь нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн **248**, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн **6**, нийцлийн **4**, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн **3** аудитыг гүйцэтгэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Үүнээс эхний 6 сарын байдлаар санхүүгийн тайлангийн 248, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 1, нийцлийн 1, аудитыг бүрэн дуусгаж, өөрийн санаачилгаар хийх гүйцэтгэлийн 2 аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажил хийгдэж байна. Аудитын хамрах хүрээнээс шалтгаалан “Засгийн газраас олгосон векселийн үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудит тус аймагт хийгдээгүй.

Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар нийт **8,851.0** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн.

Тайлант хугацаанд нийт **9.8** сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосноос **7.3** сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлж, 1.9 сая төгрөгийн төлбөрийн актыг тэргүүлэх аудиторын тушаалаар хүчингүй болгосноор гүйцэтгэл 92.4 хувьтай байна.

Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар нийт **3,988.8** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага өгсний **3,641.2** сая төгрөгийн албан шаардлагыг буюу **91** хувийг харилцагч байгууллага хугацаанд нь хэрэгжүүлж хариу ирүүлжээ.

Нийт **2,090.6** сая төгрөгийн **177** заалт бүхий зөвлөмжийг харилцагч байгууллагад хүргүүлснээс **55** заалт нь хэрэгжиж, **2,760.2** сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж ажиллав.

Байгууллага 2017 оны эхний хагас жилд нийт **5,468.7** сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.3 дахь заалтын дагуу орон нутгийн болон улсын төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд, тусгай зориулалтын сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн **1**, сумдын нэгтгэсэн тайлан **15**, нийгмийн даатгалын нэгтгэсэн тайлан **1**, Засгийн газрын тусгай сангийн

4, орон нутгийн тусгай зориулалтын сан 64, төсвийн шууд захирагчийн 143, ОНӨААТҮГ-ын 19, ТӨҮГ-ын 1, нийт 248 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдав.

Дээрх байгууллагуудаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 63 төсвийн шууд захирагч, 64 орон нутгийн тусгай зориулалтын сан, 1 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, нийт 115 дүгнэлт гаргахаар төлөвлөснөөс 114 дүгнэлт гаргасан байна. Үүнээс 112 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт гаргаж, Хүний хөгжил санд гүйлгээ хийгдээгүй тул дүгнэлт гараагүй.

“Саруул баян уул аудит” ХХК, “Их наяд аудит” ХХК-тай гэрээ байгуулан улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, сумдын Эмийн эргэлтийн сан зэрэг нийт 46 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлсэн. Энэ нь нийт аудитын 18.5 хувийг эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитад АДБОУС, АОУС-ыг мөрдөж, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврыг шалгуур болгон ашиглаж, журам, гарын авлагын дагуу гүйцэтгэв.

Аудитад СТАУС программыг ашиглаж, аудитын үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүлээ. Байгууллагуудын санхүүгийн аудитын дүгнэлтийг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон үйлчлүүлэгч байгууллагуудын төсөв захирагч нарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,464.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитын явцад 2,760.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 2,576.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 9.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 1,127.2 сая төгрөгийн 156 заалт бүхий зөвлөмжийг тус тус өглөө.

Эхний хагас жилийн байдлаар 4,086.0 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн ба төлбөрийн актын 92.4 хувь, албан шаардлагын 83 хувь, зөвлөмжийн 35 хувь нь тус тус хэрэгжсэн байна.

Аудитад зарцуулсан хүн.цаг 4576, аудитын өртөг 51.7 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 4,086.0 сая төгрөг.

Аудитаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хамааралгүй буюу хүчингүй болсон хуулийн заалт, журам үндэслэн тушаал шийдвэр гаргаж, төсөв хөрөнгө зарцуулсан,
- Хэмнэлтийн горимд шилжих тухай тогтоолуудыг мөрдөөгүй,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, чанаргүй, дутуу хийж тооцоог бодож баталгаажуулаагүй,
- Хяналтын тооллогоор хөрөнгө дутагдсан,
- Барилгын их засварыг орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тайлагнасан, барилгын өөрийн өртөгт нэмж капиталжуулаагүй,
- Шатахууны тооцоог бодож, баталгаажуулдаггүй,
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу бүртгэж, харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй,
- Түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй,
- Цалин, нэмэгдлийг буруу тогтоосон,
- Ур чадварын нэмэгдлийг хавтгайруулж олгосон,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн,
- Сум хөгжүүлэх сангийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтан нийт 3 албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

ҮАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 2017 онд 6, өөрийн санаачилгаар 3 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу нэгдсэн удирдамжаар “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр

ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, тайланг шалгагдагч байгууллага болон ҮАГ-т хүргүүлээ. Аудитын шалгах асуудал, хамрах хүрээнээс шалтгаалан “Засгийн газраас олгосон векселийн үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудит манай аймагт хийгдээгүй.

Аудитаар нийт **1,267.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн. Үүнээс **292.3** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага /5/ хүргүүлж, хэрэгжилт 100 хувьтай, 974.7 сая төгрөгийн **4** зөвлөмж өгөгдөж, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитаас нийт 1,267.0 сая төгрөгийн 9 санхүүгийн үр өгөөж бүртгэж, тайлангийн хугацаанд **292.3** сая төгрөгийн 5 үр өгөөжийг тооцсон байна.

Аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүлээ.

Аудитад зарцуулсан хүн.цаг 2000, аудитын өртөг 13.0 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 293.0 сая төгрөг.

2017 оны эхний хагас жилд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээс товч танилцуулбал:



3.1 “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Орон нутгийн хөрөнгө оруулалт үр ашиг муутай байна.” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан боловч яамнаас хуваарилсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нь нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй, зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон, УИХ-ын 47 дугаар тогтоолыг зөрчиж АЗДТГ төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамж, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан төлөвлөгөөний дагуу 4 нийцлийн аудит хийхээр төлөвлөсөн. Эхний 6 сарын байдлаар “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д нийцлийн аудит хийж, аудитын төгсгөлийн уулзалт зохион байгуулсан. Аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүлээ.

Нийцлийн аудитаар нийт **1,119.8** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар **21** хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна.

Аудитад зарцуулсан хүн.цаг 2,296, аудитын өртөг 20.5 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын үр өгөөж 1,089.7 сая төгрөг.

2017 оны эхний хагас жилд хийсэн нийцлийн аудитын дүнгийн талаар товч танилцуулбал:



4.1 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны зарцуулалт” хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт болон иргэдийн оролцоо хангалтгүй хэвээр байна.” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь ангилбал:

- Зориулалтын бус зардалд зарцуулсан 166.2 сая төгрөг буюу 14.8 хувь;
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж санхүүжүүлсэн 524.6 сая төгрөг буюу 46.8 хувь;
- Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 216.3 сая төгрөг буюу 19.3 хувь;
- Бүртгэл, тайланд тусгаагүй 171.4 сая төгрөг буюу 15.3 хувь;
- ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 10.6 сая төгрөг буюу 0.9 хувь;
- Захиалагчийн хяналт тавиагүй /Хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлд

тусгаагүй/ 30.7 сая төгрөг буюу 2.7 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, сумдын Засаг дарга нарт болон Засаг даргын Тамгын газрын дарга нарт 17 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

4.2 “Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаа” хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Орон нутагт идлэг шонхор шувууг барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.” гэсэн дүгнэлт өглөө.



Идлэг шонхорын төлбөрийг дутуу тооцож авсан, өгөөш болгон ашиглах шувууны төлбөр хураамжийг тооцож аваагүй, орон нутагт идлэг шонхор шувууг экспортын зориулалтаар барихад хяналт хийгдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Хууль тогтоомжийг зөрчсөн дээрх зөрчлүүдийг нэгдсэн тайланд тусгуулж, БОАЖЯ-ны холбогдох албан тушаалтанд арга хэмжээ тооцохуулахаар УАГ-т уламжилсан.

Тав. Өөрийн төлөвлөгөөт аудитын талаар

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Авто замын сангийн зарцуулалт”, “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн зориулалт, үр ашиг”, “Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн”-д тус тус гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсөн.

5.1 “Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажил хийгдэж байна. Аудитаар Өлзийт, Эрдэнэдалай, Гурвансайхан, Цагаандэлгэр, Адаацаг, Сайнцагаан сумдад ажиллаж, Сум хөгжүүлэх сангаас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчдээс түүвэрлэн төслийн явцыг газар дээр нь үзэж, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, сонгон шалгаруулалтыг журмын дагуу хийж, хяналт тавьж ажилласан эсэхийг шалгалаа. Аудитын явцад зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, зээлийн гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагааны тайлан мэдээг гаргуулж, нэгтгээгүй, аудитад хамрагдсан сумдаас Эрдэнэдалайгаас бусад сумд Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, гэрээний хариуцлага тооцож ажиллаагүй, зээлдүүлэгчтэй байгуулсан Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний заалт тодорхой бус, агуулгын болон найруулга, үг үсгийн алдаатай, зарим сумд барьцааны гэрээг байгуулаагүй, сургалт зохион байгуулаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрч байна. Аудитаар дээрх зөрчлүүдийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, гэрээний хугацаандаа

төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл, зээлийг хүүг барагдуулах, зориулалт бусаар зарцуулсан зээлийг татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, төсөл хэрэгжүүлэгчдийг түүвэрлэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдлийг тулган баталгаажуулж баримтжуулах ажил хийгдэж байна.

5.2 “Авто замын сангийн зарцуулалт үр дүнд”-д хийх гүйцэтгэлийн аудит батлагдсан хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн үе шатны ажил хийгдэж байна.

Зургаа. Дотоод ажлын талаар

6.1 Байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаар:

- ❖ Үндэсний аудитын газраас ирүүлсэн 4 судалгаа, системчилсэн үнэлгээний санал асуулга, ажлын байрны тодорхойлолт болон холбогдох журмын төслүүдэд нийт 60 саналыг заасан хугацаанд нь хүргүүлээ.
- ❖ Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах зорилгоор авсан “Бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж буй асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох” санал асуулгыг бүх ажилтнууд бөглөж, илгээсэн.
- ❖ Аудитын үр нөлөөг нэмэгдүүлэх, орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй нийгэм эдийн засгийн асуудал буюу аудитын сэдэв сонгохтой холбоотой, мөн ажилтнуудын ёс суртахуун, мэргэжлийн ур чадвар, шударга байдлын талаар харилцагч байгууллага, иргэдийн төлөөлөлөөс санал асуулга авч, нэгтгэв.
- ❖ Ажлын цаг бүртгэл, ажлын цаг тооцооллын excel файлыг сайжруулан цаг бүртгэлд ашиглаж байна.
- ❖ Хамт олны дотоод үйл ажиллагаатай холбоотой аппаратын хурал 4, удирдлагын зөвлөлийн хурал 3, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар болон “Ахмадаа сонсьё” сэдэвт 2 хэлэлцүүлэг, Монгол улсын Ерөнхий аудиторов орон нутаг хариуцсан орлогчийн ажлын алба, дотоод аудитын хамтарсан үзлэг шалгалтын танилцуулга болон дүнгийн талаарх 2 удаагийн хурлын тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулан, холбогдох хүмүүст хүргүүлж, 7 хоног бүрийн шуурхай хурлын нийт 22 тэмдэглэл хөтөлж, баталгаажуулав.

6.2 Байгууллагын болон санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар:

- ❖ Дундговь аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөний үеэр 2016 онд хийгдсэн “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын дүнг сумдын Засаг дарга, сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн, бизнес эрхлэгч нарт танилцуулсан.
- ❖ Тэргүүлэх аудитор Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар ард нийтээс санал авах ажлын хэсгийн зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож, саналаа илэрхийлсэн.
- ❖ ТШЗ нарын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын дүнг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сангийн яамтай хамтран зохион байгуулсан УСНББОУС-ын сургалтын үеэр ТШЗ нарын нягтлан бодогчид, сумдын санхүүгийн албаны дарга нарт танилцуулсан.
- ❖ ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон Төлөөлөгчдийн хуралд танилцуулсан.
- ❖ Мэдээллийн ил тод байдлыг хангаж төсвийн гүйцэтгэлийн мэдээг ханын самбарт мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг shilendans.gov.mn сайтад сар бүр цаг хугацаанд нь байршуулж ажилласан.
- ❖ 2017 оны эхний хагас жилд хийгдсэн аудитын тайлан мэдээ, үйл ажиллагааны талаар нийт 54 мэдээллийг тухайн цаг хугацаанд нь УАГ-ын audit.mn вэб хуудас болон байгууллагын facebook хуудсанд байршууллаа.
- ❖ Байгууллагын цахим хуудсанд хандах хандалтын тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэх, албан хаагч, иргэдэд санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын талаар мэдлэг олгох зорилгоор долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригуудад байгууллагын facebook хуудсаар дамжуулан мэдээлэл байршуулж байна.

6.3 Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- ❖ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв хуулийн хугацаанд гаргуулан авч, нэгтгэн, тайлан мэдээг хугацаанд нь ҮАГ болон холбогдох газарт хүргүүлсэн.
- ❖ ТАБ-ын ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудит хийх бүрт ажилтнуудаар гаргуулан ажиллав.

6.4 Байгууллагын хүний нөөцийн манлайллыг хангах ажлууд:

- ❖ Мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн дагуу “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”, “Нөхцөл байдлын үнэлгээ хийх, судалгааны арга зүй, төсөл бичих арга зүй, шинжилгээний аргууд” сэдвээр тус тус дотоод сургалтууд зохион байгуулж, бүх ажилтнууд хамрагдсан.
- ❖ Аймгийн Шүүхийн Тамгын газартай хамтран “Хөдөлмөрийн тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль” сэдвээр, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан УСНББОУС, НББОУС-ын 3 өдрийн сургалт, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 2017 оны 03 сарын 31-ны өдөр зохион байгуулсан төрийн албан хаагч нарт зориулсан “Үндэсний аюулгүй байдлыг хангахад орон нутгийн удирдах албан тушаалтнуудын үүрэг оролцоо”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа”-сэдэвт сургалт, Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан “Зөрчлийн тухай хууль”-ийн сургалтуудад бүх ажилтнууд хамрагдсан.
- ❖ E-Views, SPSS програмуудын талаар мэргэжлийн багшаар заалгаж, Visio, Project програмууд дээр хэрхэн ажиллах талаар судалж, ашиглахад бэлтгэж байна.
- ❖ Аудитын менежер Х.Наранцацрал, аудитор Т.Оюун-Эрдэнэ нар мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн сургалтанд хамрагдаж, шалгалтаа амжилттай өгснөөр хугацаагүй эрхийн гэрчилгээг авсан. Шинжээч С.Жалбаа, Д.Должинсүрэн нар мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт өгч, нийт 4 шалгалтын хөнгөлөлт аваад байна.

6.5 Бусад ажлын талаар

- ❖ Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг журмын дагуу хөтөлж, одоогийн нөөц бололцоонд тулгуурлан архивын өрөөнд 12 модон тавиур хийлгэж, байнга хадгалах хадгаламжийн нэгжийг он, оноор нь ялгаж цэгцлэв.
- ❖ ҮАГ-аас зохион байгуулсан онлайн хурлуудад тоног төхөөрөмж, сүлжээний бэлэн байдлыг хангаж, оролцсон.
- ❖ Аймгийн хэмжээнд зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээ, гүйлтийн арга хэмжээнд оролцов.
- ❖ ММНБИ-ийн Дундговь аймаг дахь салбараас зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчдын жилийн уулзалт, татварын баярт оролцлоо.
- ❖ “Ахмаддаа тусальа” аяны хүрээнд байгууллагын харьяа өндөр настан Дуламсүрэн гуайн амьдрах нөхцөлийг сайжруулж, гадна орчинг тохижуулах ажил зохион байгуулав.
- ❖ Аймгийн ЭМГ-т ажилтнуудын биеийн хөгжлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ хийлгэв.
- ❖ Хамт олны хурлын шийдвэрийн дагуу ҮАГ, Сангийн яамны жуух бичиг шагналаар шагнуулах ажилчдын ажлын үзүүлэлт, тодорхойлолтыг холбогдох газруудад хүргүүлээд байна.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

Төрийн аудитын газрын 2016 оны санхүүгийн тайланг стандартын дагуу үнэн зөв гарган хуулийн хугацаанд “Улаанбаатар аудит корпораци” ХХК –аар аудит хийлгэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр хуулийн хугацаанд гаргаж, төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг сар бүр гарган ҮАГ-т хүргүүлж ажиллав.

Батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн гүйлгээг хийж төсвийг зориулалтын дагуу зарцуулж, нийгмийн даатгал болон татварын тайланг сар, улирал бүр гаргаж баталгаажуулан, харилцагч

байгууллагуудтай тооцоог нийлэв. Тэргүүлэх аудиторын 05 сарын 26-ны өдрийн А/12 тоот тушаалаар тооллогын комисс томилж, байгууллагын 2017 оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллогыг 06 сарын 02-05-ны өдрүүдэд хийж, үр дүнг ӨХБЗ-өөр хэлэлцүүлэн, акталж устгах хөрөнгийн талаар дүгнэлт гарган, холбогдох шийдвэр гаргуулахаар материалыг УАГ болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэв.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын төсвийн гүйцэтгэлийг сар бүр дотоод сүлжээ, шилэн дансны цахим хуудас болон байгууллагын ханын самбараар олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэв.

Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2018 оны төсвийн төслийг боловсруулан баталгаажуулж, УАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2017 оны 6 сарын 30-ны байдлаар 96.4 сая төгрөгийн төсөв зарцуулахаас гүйцэтгэлээр 92.8 сая төгрөгийг холбогдох зардалд зориулалтын дагуу зарцуулж, нийт 3,6 сая төгрөгийн төсөв хэмнэж, өр, авлагагүй ажиллаж байна.

Найм. Дүгнэлт, санал

Манай хамт олон Монгол Улсын Ерөнхий аудитор, аймгийн Аудитын газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, эхний хагас жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүллээ.

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа АДБОУС, Аудитын Олон улсын стандартыг мөрдөн, Төрийн аудитын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байх үндсэн зарчмуудыг баримтлан, ёс зүйн хэм хэмжээг сахиж, сонирхлын зөрчилгүй, шударга ажилласан.

Санал:

- ❖ Аудитыг ижил түвшинд чанартай гүйцэтгэхийн тулд илэрч байгаа зөрчил дутагдлын талаар мэдээлэл харилцан солилцох, аймаг орон нутгийг холбож, аудитын гүйцэтгэлийн үе шатанд арга зүйгээр хангаж ажиллах;
- ❖ Аудитын тайлагналын дараах үе шатны ажил /зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах/ хэрэгжүүлэх болон ажилтнуудыг сурч боловсрох цаг хугацааг орон нутагт хангалттай гаргаж өгөх;
- ❖ Татвар, Нийгмийн даатгал, Улсын бүртгэл зэрэг төрийн байгууллагууд, арилжааны банк, хандивлагч байгууллагуудаас мэдээлэл солилцох, цахимаар мэдээлэл авах боломжийг судлан, УАГ нэгдсэн журмаар зохицуулах нь аудитад шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хурдан шуурхай авах нөхцөл бүрдэж, ингэснээр аудитын чанар үр өгөөж нэмэгдэх боломжтой.

ТӨРИЙН МЭЛМИЙ ХУРЦ, ТУНГАЛАГ,
ТҮМЭН ОЛОН АМГАЛАН БАЙГ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР